

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/36/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/81  
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА  
Ж.ГОМБОСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**19020269**

D 2022/2022 он/ALBAN BICHIG

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>29,939,259.08</u></b>	<b><u>30,730,807.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	212,333.55	200,482.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	212,333.55	200,482.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,726,925.53	30,530,325.53
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,472,692.21	14,472,692.21
35110	Тусгай зориулалттай материал	14,472,692.21	14,472,692.21
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,254,233.32	16,057,633.32
35410	Бичиг хэргийн материал	308,450.00	842,850.00
35420	Аж ахуйн материал	6,105,833.32	6,105,833.32
35430	Сэлбэг хэрэгсэл	3,210,000.00	3,479,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,629,950.00	5,629,950.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>147,279,102.34</u></b>	<b><u>133,352,769.61</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	147,279,102.34	133,352,769.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	47,194,769.13	33,312,436.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,513,180.00	71,513,180.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,440,743.03	-43,604,936.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,672,278.98	28,349,170.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,637,339.60	-28,349,170.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,240,000.00	1,569,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-566,908.82	-1,019,908.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,557,901.60	7,557,901.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,143,600.00	-2,702,800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	100,084,333.21	100,040,333.17
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-135,666.79	-179,666.83
39303	Бусад биет бус хөрөнгө	100,000,000.00	100,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>177,218,361.42</u></b>	<b><u>164,083,577.14</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>36,282.46</u></b>	<b><u>36,282.46</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	36,282.46	36,282.46
<b>413</b>	<b>Өглөг</b>	36,282.46	36,282.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,282.46	36,282.46
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>177,182,078.96</u></b>	<b><u>164,047,294.68</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	177,182,078.96	164,047,294.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	100,000,000.00	100,000,000.00
51101	Өмч: - төрийн	100,000,000.00	100,000,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	77,182,078.96	64,047,294.68
51210	Өмнөх үеийн үр дүн	77,182,078.96	77,182,078.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-13,134,784.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>177,218,361.42</u></b>	<b><u>164,083,577.14</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	47,162,300.00	<b>47,162,300.02</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.02</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	00.02
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	00.02
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	00.00	<b>47,162,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	47,162,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	47,162,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>63,408,099.07</b>	<b>60,297,084.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>63,408,099.07</b>	<b>60,297,084.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	61,770,588.12	53,835,325.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	34,252,391.42	31,646,769.95
210101	Үндсэн цалин	34,252,391.42	31,646,769.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,386,564.62	4,110,235.66
210201	Тэтгэврийн даатгал	2,926,041.83	2,845,372.02
210202	Тэтгэмжийн даатгал	434,494.25	316,467.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	275,391.61	253,174.13
210204	Ажилгүйдлийн даатгал	118,226.27	62,286.42
210205	Эрүүл мэндийн даатгал	632,410.66	632,935.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,644,500.00	3,222,712.00
210401	Бичиг хэрэг	602,200.00	140,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,310,000.00	2,465,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,500.00	442,212.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	155,800.00	175,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,000,000.00	180,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	180,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	518,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	518,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	969,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	969,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	272,333.00	231,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,233.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	41,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,245,799.08	13,926,332.75
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,245,799.08	13,926,332.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,637,510.95	6,461,758.94
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	779,200.00	830,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	80,640.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	698,560.00	830,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	858,310.95	5,631,758.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	858,310.95	5,631,758.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-16,245,799.07</b>	<b>-13,134,784.28</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-16,245,799.07</b>	<b>-13,134,784.28</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	100,000,000.00	00.00	93,427,878.03	00.00	193,427,878.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>93,427,878.03</b>	<b>00.00</b>	<b>193,427,878.03</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,245,799.07	00.00	-16,245,799.07
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>77,182,078.96</b>	<b>00.00</b>	<b>177,182,078.96</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>77,182,078.96</b>	<b>00.00</b>	<b>177,182,078.96</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>77,182,078.96</b>	<b>00.00</b>	<b>177,182,078.96</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,134,784.28	00.00	-13,134,784.28
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>64,047,294.68</b>	<b>00.00</b>	<b>164,047,294.68</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>47,162,300.00</b>	<b>47,162,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>47,162,300.00</b>	<b>47,162,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	47,162,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	47,162,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	47,162,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>46,303,989.05</b>	<b>41,530,541.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>46,303,989.05</b>	<b>41,530,541.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,524,789.05</b>	<b>40,520,441.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	34,252,391.42	31,634,918.40
210101	Үндсэн цалин	34,252,391.42	31,634,918.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,386,564.63	4,110,235.66
210201	Тэтгэврийн даатгал	3,018,203.96	2,845,372.04
210202	Тэтгэмжийн даатгал	304,514.60	316,467.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	316,714.69	253,174.09
210204	Ажилгүйдлийн даатгал	68,958.05	62,286.43
210205	Эрүүл мэндийн даатгал	678,173.33	632,935.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,644,500.00	3,707,112.00
210401	Бичиг хэрэг	618,700.00	674,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,310,000.00	2,415,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	395,000.00	442,212.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	320,800.00	175,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	837,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	837,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	969,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	969,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	272,333.00	231,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,233.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	41,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	8,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>779,200.00</b>	<b>1,010,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	779,200.00	1,010,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	779,200.00	1,010,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>858,310.95</b>	<b>5,631,758.94</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	858,310.95	5,631,758.94
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	47,162,300.00	41,530,541.06	5,631,758.94	88.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	47,162,300.00	41,530,541.06	5,631,758.94	88.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	45,312,300.00	40,520,441.06	4,791,858.94	89.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	34,278,800.00	31,634,918.40	2,643,881.60	92.29
210101	Үндсэн цалин	34,278,800.00	31,634,918.40	2,643,881.60	92.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,627,600.00	4,110,235.66	517,364.34	88.82
210201	Тэтгэврийн даатгал	3,256,500.00	2,845,372.04	411,127.96	87.38
210202	Тэтгэмжийн даатгал	342,800.00	316,467.70	26,332.30	92.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,200.00	253,174.09	21,025.91	92.33
210204	Ажилгүйдлийн даатгал	68,600.00	62,286.43	6,313.57	90.80
210205	Эрүүл мэндийн даатгал	685,500.00	632,935.40	52,564.60	92.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,038,000.00	00.00	1,038,000.00	-
210301	Гэрэл, цахилгаан	525,000.00	00.00	525,000.00	-
210302	Түлш, халаалт	513,000.00	00.00	513,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,989,900.00	3,707,112.00	282,788.00	92.91
210401	Бичиг хэрэг	674,900.00	674,900.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,520,000.00	2,415,000.00	105,000.00	95.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	445,000.00	442,212.00	2,788.00	99.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350,000.00	175,000.00	175,000.00	50.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,026,000.00	837,000.00	189,000.00	81.58
210604	Урсгал засвар	1,026,000.00	837,000.00	189,000.00	81.58
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	352,000.00	231,175.00	120,825.00	65.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	146,600.00	81,675.00	64,925.00	55.71
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	41,500.00	14,400.00	74.24
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	8,000.00	41,500.00	16.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1850000.00	1010100.00	839,900.00	54.60
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,850,000.00	1,010,100.00	839,900.00	54.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00	1,010,100.00	839,900.00	54.60
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	47,162,700.00	47,162,300.00	400.00	100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	47,162,700.00	47,162,300.00	400.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	47,162,700.00	47,162,300.00	400.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	05.00	07.00	(2.00)	140.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	05.00	(2.00)	166.67
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	-	-
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, бараа материалын бүртгэлийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн анги нь ойн баялгийн нөөцийг тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн даргын тушаалаар Байгууллагын дотоод журмыг баталсан байна.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 47,162.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 707.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 530.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 47,162.7 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 71,513.2 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 16,672.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,240.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 7,557.9 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 220.0 мянган төгрөгийн программ хангамж, 100,000.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө, нийт 197,203.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 3,909.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 3,105.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 30,530.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 200.5 мянган төгрөг, өглөг 36.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь ажиллагсадтай холбоотой авлага, харилцагч байгууллагатай холбоотой өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 30,530.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 133,352.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	212.33	200.48	(11.85)
Урьдчилгаа			-
Бараа материал	29,726.93	30,530.33	803.40
Үндсэн хөрөнгө	147,279.10	133,352.77	(13,926.33)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>177,218.36</b>	<b>164,083.58</b>	<b>(13,134.78)</b>
Өр төлбөр	36.28	36.28	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	177,182.08	164,047.29	(13,134.78)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>177,218.36</b>	<b>164,083.58</b>	<b>(13,134.78)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 30,530.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 803.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 133,352.8 мянган төгрөг болж 13,926.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 164,047.3 мянган төгрөг болж 13,134.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 47,162.7 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 45,312.7 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 1,850.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 45,312.7 мянган төгрөгийн урсгал зардал, 1,850.0 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 47,162.7 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 41,530.5 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 5,631.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 41,530.5 мянган төгрөг буюу 88.1 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансанд 4 нэр төрлийн 2,959.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй хөрөнгө материалыг зөв ангилан бүртгээгүй байна. Тайлант хугацаанд нягтлан бодогч солигдсоноос анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй зөрчил илэрч байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлан дах хөрөнгийн бүртгэлд аймгийн БОАЖГ болон Мөнгөнморьт сум дундын ойн ангид ашиглагддаг 12 нэр төрлийн 44,349.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Хөрөнгийн тооллогоор дээрх хөрөнгийн байршлыг тодорхойлон тоолж, баталгаажуулаагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 7,596.2 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,195.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 38.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 44,349.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 3,808.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

##### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 38.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацааны 8 дугаар сард 2 албан хаагчид амралтын мөнгө олгохдоо ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 38.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн дутуу суутгасан ХХОАТ-ыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Санхүүгийн тайлан дах хөрөнгийн бүртгэлийг жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулгахад 12 нэр төрлийн 44,349.3 мянган төгрөгийн хөрөнгө тоологдоогүй бөгөөд энэхүү тоологдоогүй хөрөнгө нь аймгийн БОАЖГ болон Мөнгөнморьт сум дундын ойн ангид ашиглагддаг боловч байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй байгаа нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж, хөрөнгийн байршлыг тодорхойлж, бусад байгууллагад ашиглагддаг хөрөнгийг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны харилцах дансаар хийгдсэн ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 849.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй гүйцэтгэсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй, "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх

## **2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд 4 нэр төрлийн 2,959.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12 болон УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн анги	4	48,195.5	-	-	1	38.0	1	44,349.3	2	3,808.2

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)